


БАТЛАВ:

СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР



Н.ЭРДЭНЭХҮҮ

**ШУТИС-ИЙН 65 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ ШАЛГАРУУЛАХ”
ХУРЛЫН УДИРДАМЖ**

Зорилго:

Их сургуульд суралцагч оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулж, нийтийн хүртээл болгох.

Хамрах хүрээ:

Их сургуулийн бакалаврын түвшинд суралцагч оюутнууд (суралцагч гадаад оюутнууд) оролцоно.

Хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 22-нд зохион байгуулна.

I. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:

1. Асуудлаа тодорхойлсон байдал, хэрэглээ, ач холбогдол
2. Тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог шийдэл
3. Техник технологи, эдийн засгийн судалгаа, тооцоолол
4. Оюутны илтгэх ур чадвар
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь бичлэгийн стандарт шаардлагыг хангасан байдал. Өгүүллийн хуудасны тоо 5-аас хэтрэхгүй байх

Жич: ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.

Холбоос: <https://research.must.edu.mn/page/104>

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийг шалгаруулах салбар:

Салбар 1. Техник, технологи (Инженерийн болон технологийн чиглэлийн судалгааны ажил хамаарна)

Салбар 2. Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан (Математик, физик, хими, биологи, экологи, газар зүйн мэдээллийн систем хамаарна)

Салбар 3. Нийгэм, хүмүүнлэгийн ухаан (Нийгэм, соёл, дизайн, эдийн засаг, менежмент, хэл шинжлэлийн чиглэлийн судалгааны ажил хамаарна)

Шалгаруулалт, үе шат

Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийн шалгаруулалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулна.

Бүрэлдэхүүн сургуулиуд оюутны судалгааны ажил, багш оюутны хамтын ажиллагааг дэмжих байдлаар шилдэг өгүүллийг салбар тус бүрт 2-3 өгүүллийг

хэвлэмэл болон файл хэлбэрээр, албан бичгийн хамт 2024 оны 11 дүгээр сарын 06-ны дотор чуулган зохион байгуулах комисст ирүүлнэ. (файл, ррт-г studentservice@must.edu.mn, хэвлэмэл материалыг хичээлийн I байр 327 тоотод).

Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулах нэгдсэн хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-нд Техник, технологиин салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 604 тоот, Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухааны салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 405 тоот “Хурлын танхим”-д, Нийгэм хүмүүнлэгийн салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 602 тоот танхимд тус тус зохион байгуулагдана.

Шагнал урамшуулал:

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийг салбар тус бүрт 3 хүртэл байр эзлүүлэн шагнан урамшуулна. (Шүүгчдийн саналыг үндэслэн салбар хуралдааны оролцоо, үр дүнгээс хамаарч байр, шагналд өөрчлөлт оруулах боломжтой)

I байр Батламж, 1000.000 төгрөг

II байр Батламж, 750.000 төгрөг

III байр Батламж, 500.000 төгрөг

Оюутны эрдэм шинжилгээний өгүүллийг удирдан ажилласан удирдагч багш нараас шилдэг удирдагч багшийг тус тус шалгаруулан батламж, мөнгөн шагналаар шагнан урамшуулна.

Оюутнуудын шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг эмхтгэн хэвлэж хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.

Холбогдох майл хаяг, утас:

Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний
алба хичээлийн I байр 327 тоот өрөө
321184, 324590-1035

[/studentservice@must.edu.mn /](mailto:studentservice@must.edu.mn)

ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС